



ТӨВ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
XX ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 04

Зуунмод

Төсөл, арга хэмжээний нэр өөрчлөх  
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.9, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVII хуралдааны 03 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан аймгийн "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт"-ын шинээр эхлэх их засварын ажлуудын 2.20 дахь хэсэг "Эрдэнэсант сумын бага сургуулийн засвар" 130,000,000 /нэг зуун гучин сая/ төгрөг төсөл, арга хэмжээ гэснийг "Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн засвар" 130,000,000 (нэг зуун гучин сая) төгрөг гэж өөрчлөлт оруулсугай.

2. Аймгийн "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан хууль, тогтоомжийн хүрээнд холбогдох зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-т даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороонд даалгасугай.

ДАРГА



Д.ЖАМБАЛСҮРЭН

4124010083



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/461

Зуунмод

Төв аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан батлах, эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2, 44.4, 45 дугаар зүйлийн 45.5, 45.6, 45.7 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 20 дугаар хуралдааны 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2024 оны А/01 дүгээр захирамжаар батлагдсан “2024 оны төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө жагсаалтын нэгдүгээр хавсралтын 61-т “Эрдэнэсант сумын бага сургуулийн засвар” 130,000,000 (нэг зуун гучин сая) төгрөгөөр батлагдсан төсөл, арга хэмжээг “Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн засвар” 130,000,000 (нэг зуун гучин сая) төгрөг гэж өөрчлөн хавсралтаар баталсугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг Эрдэнэсант сумын Засаг даргад эрх шилжүүлж, хэрэгжилтэд мэргэшлийн дэмжлэг үзүүлэн ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газарт даалгасугай.

3. Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-ээр шуурхай зохион байгуулж, тендерийн урилга, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, үр дүн, гэрээ, ажил хүлээж авсан актыг тухай бүр цахим системд нийтэлж байхыг сумын Засаг дарга, захиалагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Саран-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4124010922

Төв аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/УБГ дугаар захирамжийн хавсралт

ТӨВ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ /ӨӨРИЙН БАГЦ/-ИЙН  
2024 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ, ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

д/д	Тендер шалгаруулалтын код	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл (бараа, ажил, үйлчилгээ)	Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Тендер шалгаруулалтын арга	Тендер шалгаруулалт зарлах огноо	Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлт тавих эсэх	Тайлбар, тодруулга
0	2	3	4	5	6	7	8	9	10
<b>ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ</b>									
1		Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвийн засвар	Ажил	130,000,000	130,000,000	ХА	2024		Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 20 дугаар хуралдааны 2024 оны 07 дугаар сарын 01-ны 04 дүгээр тогтоолоор төсөл, арга хэмжээний нэр өөрчилсөн.
		<b>ДҮН</b>		<b>130,000,000</b>	<b>130,000,000</b>				

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.САРАН-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

А.ЗОРИГОО

